

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/38/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Орхон аймаг 2024 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: <a href="mailto:narmandakhts@audit.gov.mn">narmandakhts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: <a href="mailto:buyanundrakhb@audit.gov.mn">buyanundrakhb@audit.gov.mn</a> Аудитор: Ц.Одгэрэл Утас: 70357955 Цахим хаяг: <a href="mailto:odgerelts@audit.gov.mn">odgerelts@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.25 № 28

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ХОТ  
ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ДАРГА  
Б.МӨНХДАЛАЙ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, 12 иргэнтэй байгуулсан гэрээний төлбөр болох 63.6 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан босго үнийг үндэслэж тендерийн журмыг сонгоогүй 596.9 сая төгрөгийн давс, 61.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 85.4 сая төгрөгийн автомашины дугуй, 30.5 сая төгрөгийн засварын материал, 51.6 сая төгрөгийн хүнсний материал, нийт 826.3 сая төгрөгийн бараа материал шууд худалдан авсан.
- Сум худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүй 2 иргэнээс 30.5 сая төгрөгийн 140 хайрцаг сум худалдан авсан.

4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаагүй, тайлант оны эцэст 91.7 сая төгрөгийн авлага, 95.6 сая төгрөгийн өглөгийг тус тус барагдуулаагүй, өмнөх оноос 87.9 сая төгрөгөөр авлагыг нэмэгдүүлсэн.
5. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангаагүй, тайлант онд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Орхон аймгийн Хот тохижуулах газар нь тайлант онд "Хог хаягдлын менежментийг сайжруулах" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,933.9 сая төгрөгийн тусгай тоноглол бүхий 7 ширхэг хог ачих зориулалттай автомашин, 552.4 сая төгрөгийн 65 ширхэг зөөврийн хогийн сав үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

#### **Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Хот байгуулалт, тохижилт хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,593.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 784.1 сая төгрөгийг орон нутгийн болон бусад байгууллагаас шилжүүлсэн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 8,593.5 сая төгрөгийн, орон нутгийн болон бусад байгууллагын төсвөөс 784.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 8,944.9 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, орон нутгийн төсөвт 432.7 сая төгрөг буцаан төвлөрүүлжээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name 'Ц.НАРМАНДАХ' and the title 'ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР'.

Ц.НАРМАНДАХ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>281,144,159.32</b>	<b>682,302,906.86</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,725,191.28</b>	<b>91,663,389.68</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,725,191.28	26,200.68
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>91,637,189.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	00.00	91,425,631.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	211,558.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>277,418,968.04</b>	<b>590,639,517.18</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>72,308,100.00</b>	<b>320,322,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	72,308,100.00	320,322,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>205,110,868.04</b>	<b>270,317,517.18</b>
35410	Бичиг хэргийн материал	302,750.00	98,000.00
35420	Аж ахуйн материал	86,743,570.04	86,258,089.18
35430	Сэлбэг хэрэгсэл	13,121,500.00	70,866,900.00
35450	Барилгын засварын материал	85,130,975.00	98,444,030.00
35460	Хүнсний материал	5,140,575.00	129,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,671,498.00	14,521,498.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>41,711,193,644.68</b>	<b>49,386,178,722.39</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>41,711,193,644.68</b>	<b>49,386,178,722.39</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>41,204,993,644.68</b>	<b>48,879,978,722.39</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,390,606.29	1,246,390,606.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-415,809,677.58	-459,203,690.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,685,461,508.00	6,551,833,400.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,477,610,374.80	-3,491,107,825.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	217,435,037.00	359,394,525.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,883,167.00	-126,970,846.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,637,576.00	115,895,966.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,915,454.23	-107,692,876.55
39209	Зам, гүүрийн байгууламж	42,179,152,927.06	49,201,215,070.05
39210	Хуримтлагдсан элэгдэл	-18,688,994,202.26	-23,114,125,166.70
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,952,313,856.40	26,843,951,157.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,420,184,990.20	-8,139,601,596.75
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>506,200,000.00</b>	<b>506,200,000.00</b>
39301	Программ хангамж	1,562,000.00	1,397,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,562,000.00	-1,397,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	506,200,000.00	506,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>41,992,337,804.00</b>	<b>50,068,481,629.25</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>140,384,190.00</b>	<b>95,607,702.31</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>140,384,190.00</b>	<b>95,607,702.31</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>140,384,190.00</b>	<b>95,607,702.31</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	59,458,366.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	130,036,690.00	3,810,710.42
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>10,347,500.00</b>	<b>32,338,624.99</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	9,250,600.00	31,365,824.99
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,096,900.00	972,800.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>41,851,953,614.00</b>	<b>49,972,873,926.94</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>41851953614.00</b>	<b>49972873926.94</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>7,235,927,847.02</b>	<b>7,235,927,847.02</b>
51101	Өмч: - төрийн	7,235,927,847.02	7,235,927,847.02
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>29,230,377,049.37</b>	<b>37,351,297,362.31</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	29,230,377,049.37	29,230,377,049.37
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	8,120,920,312.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,385,648,717.61	5,385,648,717.61
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>41,992,337,804.00</b>	<b>50,068,481,629.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>17,353,616,278.52</b>	<b>24,013,435,435.19</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,227,375,078.52</b>	<b>14,635,789,885.19</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,227,375,078.52</b>	<b>14,635,789,885.19</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,585,110.00	1,031,300,334.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,585,110.00	1,031,300,334.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>7,126,241,200.00</b>	<b>9,377,645,550.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,847,515,300.00</b>	<b>00.00</b>
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,847,515,300.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	250,721,900.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>525,000.00</b>	<b>784,102,050.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	783,752,050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	350,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>5,027,479,000.00</b>	<b>8,593,543,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,027,479,000.00	8,593,543,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>12,485,472,078.11</b>	<b>15,892,515,122.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,485,472,078.11</b>	<b>15,892,515,122.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,983,575,749.10</b>	<b>15,241,054,232.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,986,919,680.12</b>	<b>3,547,513,383.34</b>
210101	Үндсэн цалин	1,537,504,598.13	2,403,209,412.98
210102	Нэмэгдэл	386,581,583.59	939,365,101.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,331,688.35	18,938,494.95
210104	Урамшуулал	46,501,810.05	186,000,374.12
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>270,408,955.99</b>	<b>508,396,097.47</b>
210201	Тэтгэврийн даатгал	168,633,647.04	282,238,198.15
210202	Тэтгэмжийн даатгал	19,728,059.07	34,135,199.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	41,239,755.66	116,867,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,582,350.59	6,832,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,225,143.63	68,322,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,322,000.00</b>	<b>66,132,710.42</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,421,850.00	9,658,071.93
210302	Түлш, халаалт	39,009,529.00	42,252,638.49
210303	Цэвэр, бохир ус	13,890,621.00	13,722,000.00
210304	Байрны түрээс	00.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,446,407,461.72</b>	<b>1,739,193,706.11</b>
210401	Бичиг хэрэг	5,666,110.00	10,618,750.00
210402	Тээвэр, шатахуун	1,353,774,970.00	1,668,427,703.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,537,051.00	2,379,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,281,050.00	43,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,148,280.72	14,328,053.11
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>93,112,835.24</b>	<b>151,536,517.00</b>
210502	Хоол, хүнс	33,463,460.06	56,848,125.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,649,375.18	94,688,392.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>302,126,687.00</b>	<b>408,336,565.47</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,273,535.00	62,172,067.47
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	66,853,450.00	81,169,274.00
210604	Урсгал засвар	198,999,702.00	264,995,224.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>581,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	581,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,486,747,447.10</b>	<b>1,903,831,755.58</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,406,762,295.10	1,808,686,418.58
210803	Даатгалын үйлчилгээ	12,500,000.00	13,308,352.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,492,300.00	9,652,685.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,089,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	8,000,000.00
210807	Газрын төлбөр	62,903,852.00	64,184,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,335,530,681.93</b>	<b>6,915,531,597.48</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,325,929,081.93	6,915,531,597.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>501,896,329.01</b>	<b>651,460,889.38</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>250,721,900.00</b>	<b>00.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	250,721,900.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>209,114,663.00</b>	<b>218,744,024.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	196,201,563.00	204,292,943.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,913,100.00	14,451,081.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,956,873.53</b>	<b>89,491,011.28</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,956,873.53	89,491,011.28
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>39,102,892.48</b>	<b>343,225,854.10</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,102,892.48	343,225,854.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,868,144,200.41</b>	<b>8,120,920,312.94</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>4,868,144,200.41</b>	<b>8,120,920,312.94</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>7,126,241,200.00</b>	<b>9,377,645,550.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>7,126,241,200.00</b>	<b>9,377,645,550.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,847,515,300.00</b>	<b>00.00</b>
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,847,515,300.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	250,721,900.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>525,000.00</b>	<b>784,102,050.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	783,752,050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	350,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>5,027,479,000.00</b>	<b>8,593,543,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,027,479,000.00	8,593,543,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>7,126,241,200.00</b>	<b>9,375,245,550.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,126,241,200.00</b>	<b>9,375,245,550.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,624,344,870.99</b>	<b>8,723,784,660.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,986,944,436.72</b>	<b>3,487,772,516.44</b>
210101	Үндсэн цалин	1,537,504,598.13	2,343,468,546.08
210102	Нэмэгдэл	386,606,340.19	939,365,101.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,331,688.35	18,938,494.95
210104	Урамшуулал	46,501,810.05	186,000,374.12
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>270,868,449.27</b>	<b>508,422,298.15</b>
210201	Тэтгэврийн даатгал	168,633,647.04	282,238,198.15
210202	Тэтгэмжийн даатгал	19,783,703.31	34,161,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	41,605,389.72	116,867,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,620,565.57	6,832,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,225,143.63	68,322,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,322,000.00</b>	<b>62,322,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,600,000.00	9,600,000.00

210302	Түлш, халаалт	38,959,707.00	38,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,762,293.00	13,722,000.00
210304	Байрны түрээс	00.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,217,196,221.00</b>	<b>1,914,399,264.00</b>
210401	Бичиг хэрэг	5,416,200.00	10,750,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,124,667,570.00	1,824,516,814.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,537,051.00	2,673,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,549,800.00	61,860,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,025,600.00	14,598,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>100,121,686.00</b>	<b>146,300,840.00</b>
210502	Хоол, хүнс	40,484,450.00	51,618,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,637,236.00	94,682,290.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>296,345,650.00</b>	<b>411,931,776.59</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,815,000.00	65,686,560.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	67,618,200.00	81,121,390.00
210604	Урсгал засвар	192,912,450.00	265,123,826.59
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>581,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	581,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,680,946,028.00</b>	<b>2,192,054,065.44</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,600,960,876.00	2,099,899,662.44
210803	Даатгалын үйлчилгээ	12,500,000.00	14,642,103.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,492,300.00	5,328,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,089,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	8,000,000.00
210807	Газрын төлбөр	62,903,852.00	64,184,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,600,400.00</b>	<b>00.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,600,400.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>501,896,329.01</b>	<b>651,460,889.38</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>250,721,900.00</b>	<b>00.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	250,721,900.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>209,114,663.00</b>	<b>218,744,024.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	196,101,563.00	204,292,943.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,013,100.00	14,451,081.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,956,873.53</b>	<b>89,491,011.28</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,956,873.53	89,491,011.28
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>39,102,892.48</b>	<b>343,225,854.10</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,102,892.48	343,225,854.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>2,400,000.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>2,400,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>2,400,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>2,400,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	00.00	2,400,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-2,400,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,235,927,847.02</b>	<b>5,385,648,717.61</b>	<b>18,287,978,059.71</b>	<b>30,909,554,624.34</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>7,235,927,847.02</b>	<b>5,385,648,717.61</b>	<b>18,287,978,059.71</b>	<b>30,909,554,624.34</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,868,144,200.41	4,868,144,200.41
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,235,927,847.02</b>	<b>5,385,648,717.61</b>	<b>29,230,377,049.37</b>	<b>41,851,953,614.00</b>
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,235,927,847.02</b>	<b>5,385,648,717.61</b>	<b>29,230,377,049.37</b>	<b>41,851,953,614.00</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>7,235,927,847.02</b>	<b>5,385,648,717.61</b>	<b>29,230,377,049.37</b>	<b>41,851,953,614.00</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,120,920,312.94	8,120,920,312.94
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,235,927,847.02</b>	<b>5,385,648,717.61</b>	<b>37,351,297,362.31</b>	<b>49,972,873,926.94</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	0.00
<b>2</b>	<b>1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,593,543,500.00</b>	<b>8,250,317,645.90</b>	<b>343,225,854.10</b>	<b>96.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,593,543,500.00</b>	<b>8,250,317,645.90</b>	<b>343,225,854.10</b>	<b>96.01</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>8,283,105,600.00</b>	<b>8,031,973,621.90</b>	<b>251,131,978.10</b>	<b>96.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>3,416,137,700.00</b>	<b>3,399,103,257.87</b>	<b>17,034,442.13</b>	<b>99.50</b>
210101	Үндсэн цалин	2,642,722,000.00	2,286,762,887.49	355,959,112.51	86.53
210102	Нэмэгдэл	773,415,700.00	907,401,501.31	(133,985,801.31)	117.32
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	-	18,938,494.95	(18,938,494.95)	0.00
210104	Урамшуулал	-	186,000,374.12	(186,000,374.12)	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>495,340,100.00</b>	<b>495,340,100.00</b>	-	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	269,156,000.00	269,156,000.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	34,161,400.00	34,161,400.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	116,867,600.00	116,867,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,832,300.00	6,832,300.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	68,322,800.00	68,322,800.00	-	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой зардал</b>	<b>62,322,000.00</b>	<b>62,322,000.00</b>	-	<b>100.00</b>
210301	Гэрэл цахилгаан	9,600,000.00	9,600,000.00	-	100.00

210302	Түлш, халаалт	38,500,000.00	38,500,000.00	-	100.00
210303	Цэвэр бохир ус	13,722,000.00	13,722,000.00	-	100.00
210304	Байрны түрээс	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2104</b>	<b>Хангамж материалын зардал</b>	<b>1,827,680,600.00</b>	<b>1,653,350,182.00</b>	<b>174,330,418.00</b>	<b>90.46</b>
210401	Бичиг хэрэг	10,411,400.00	10,411,400.00	-	100.00
210402	Тээвэр шатахуун	1,722,148,400.00	1,566,578,332.00	10,938,368.00	90.97
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	2,673,200.00	2,673,200.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал, ариутгал	80,549,800.00	61,860,000.00	18,689,800.00	76.80
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	11,897,800.00	11,827,250.00	70,550.00	99.41
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>143,581,500.00</b>	<b>141,880,840.00</b>	<b>1,700,660.00</b>	<b>98.82</b>
210502	Хоол хүнс	51,981,500.00	51,618,550.00	362,950.00	99.30
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	91,600,000.00	90,262,290.00	1,337,710.00	98.54
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>386,341,100.00</b>	<b>362,390,776.59</b>	<b>23,950,323.41</b>	<b>93.80</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	66,995,000.00	65,686,560.00	1,308,440.00	98.05
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	98,462,300.00	78,452,390.00	20,010,110.00	79.68
210604	Урсгал засвар	220,883,800.00	218,251,826.59	2,631,973.41	98.81
<b>2107</b>	<b>Томилолт зочны зардал</b>	<b>690,500.00</b>	<b>581,900.00</b>	<b>108,600.00</b>	<b>84.27</b>
210702	Дотоод албан томилолт	690,500.00	581,900.00	108,600.00	84.27
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>1,951,012,100.00</b>	<b>1,917,004,565.44</b>	<b>34,007,534.56</b>	<b>98.26</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,866,668,600.00	1,836,942,162.44	176,758,137.56	98.41
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,280,000.00	-	2,280,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,518,500.00	10,506,403.00	(31,603.00)	99.88
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,770,700.00	5,371,700.00	442,800.00	93.09
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,590,000.00	-	1,590,000.00	0.00
210807	Газрын төлбөр	64,184,300.00	64,184,300.00	-	100.00
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>310,437,900.00</b>	<b>218,344,024.00</b>	<b>92,093,876.00</b>	<b>70.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>310,437,900.00</b>	<b>218,344,024.00</b>	<b>92,093,876.00</b>	<b>70.33</b>
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	295,716,300.00	204,292,943.00	91,423,357.00	69.08
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	14,721,600.00	14,051,081.00	670,519.00	95.45
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>8,593,543,500.00</b>	<b>8,593,543,500.00</b>	-	<b>100.00</b>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	8,593,543,500.00	8,593,543,500.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	8,593,543,500.00	8,593,543,500.00	-	100.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	<b>0.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	<b>0.00</b>
<b>6</b>	<b>Төсвийн бусад мэдээллийн ангилал</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0.00</b>
61	Байгууллагын тоо	1	1	0	0.00
62	Ажиллагсдын тоо	243	279	-36	114.81
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	224	260	-36	116.07

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	0.00
<b>2</b>	<b>1. НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>784,102,050.00</b>	<b>694,611,038.72</b>	<b>89,491,011.28</b>	<b>88.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>783,402,050.00</b>	<b>694,211,038.72</b>	<b>89,191,011.28</b>	<b>88.61</b>

<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>783,402,050.00</b>	<b>694,211,038.72</b>	<b>89,191,011.28</b>	<b>88.61</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>145,475,680.00</b>	<b>88,669,258.57</b>	<b>56,806,421.43</b>	<b>60.95</b>
210101	Үндсэн цалин	100,685,310.00	56,705,658.59	43,979,651.41	56.32
210102	Нэмэгдэл	44,790,370.00	31,963,599.98	12,826,770.02	71.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,994,020.00</b>	<b>13,082,198.15</b>	<b>10,911,821.85</b>	<b>54.52</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,994,020.00	13,082,198.15	10,911,821.85	54.52
<b>2104</b>	<b>Хангамж материалын зардал</b>	<b>117,985,550.00</b>	<b>116,417,382.00</b>	<b>1,568,168.00</b>	<b>98.67</b>
210401	Бичиг хэрэг	690,000.00	339,000.00	351,000.00	49.13
210402	Тээвэр шатахуун	113,383,950.00	113,306,782.00	77,168.00	99.93
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	3,911,600.00	2,771,600.00	1,140,000.00	70.86
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>15,015,000.00</b>	<b>15,015,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210502	Хоол хүнс	10,595,000.00	10,595,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	4,420,000.00	4,420,000.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>62,732,000.00</b>	<b>49,541,000.00</b>	<b>13,191,000.00</b>	<b>78.97</b>
210601	Багаж,техник, хэрэгсэл	4,000,000.00	-	4,000,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,800,000.00	2,669,000.00	2,131,000.00	55.60
210604	Урсгал засвар	53,932,000.00	46,872,000.00	7,060,000.00	86.91
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>418,199,800.00</b>	<b>411,486,200.00</b>	<b>6,713,600.00</b>	<b>98.39</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	412,694,200.00	407,394,200.00	5,300,000.00	98.72
210803	Даатгалын үйлчилгээ	4,092,000.00	4,092,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,053,600.00	-	1,053,600.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	360,000.00	-	360,000.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>400,000.00</b>	<b>300,000.00</b>	<b>57.14</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	400,000.00	300,000.00	57.14
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>784,102,050.00</b>	<b>784,102,050.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
350013	ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	783,752,050.00	783,752,050.00	-	100.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	350,000.00	-	100.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.00</b>
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	1	1	0	0.00
61	Байгууллагын тоо	1	1	0	0.00
62	Ажиллагсдын тоо	243	279	-36	114.81
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	224	260	-36	116.07

## **Гурав. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 874,329.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 874,329.6 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

### **Залруулсан алдаа:**

- Санхүүгийн тайланд 88,177.5 мянган төгрөгийн өр төлбөрийг тусгаагүй нь УСНББОУС 1, 28, 29, 30 болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн байдлын тайланд залруулав.
- Санхүүгийн тайланд 783,752.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг буруу тайлагнасан нь УСНББОУС 1 болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд залруулав.
- Мөнгөн гүйлгээний тайланд тайлант онд худалдан авсан 2,400.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын мөнгөн зардлаар тайлагнаагүй нь УСНББОУС 1, 2, 17 болон аудитын ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний тайланд залруулав.

Аудитаар нийт 293,864.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 283,589.8 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,275.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Телевизийн цэнгээнт нэвтрүүлэг бэлтгэхэд 1,000.0 мянган төгрөг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, 12 иргэнтэй байгуулсан гэрээний төлбөр болох 63,654.8 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан босго үнийг үндэслэж тендерийн журмыг сонгоогүй бараа материал шууд худалдан авсан, сум худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүй 2 иргэнээс 30,450.0 мянган төгрөгийн сум худалдан авсан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаагүй, тайлант оны эцэст 187,271.1 мянган төгрөгийн өр, авлагыг барагдуулаагүй зэрэг 281,375.9 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангаагүй, тайлант онд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт 1:**

Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт, нэхэмжлэхийг ажил үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ зэргийг бараа, ажил үйлчилгээ тус бүрээр авч байх.

### **Илрүүлэлт 2:**

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу 4,275.0 мянган төгрөгийн шагнал, урамшууллыг тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас гарган түр ажилласан хүний хувийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтын иж бүрдлийг ханган, шагнал, урамшууллыг хууль, тогтоомжид нийцүүлэн олгох.

## **2. Урсгал зардалтай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт 3:**

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 3 байгууллагатай гэрээ байгуулан 5,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл

ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, гэрээний заалтыг мөрдөн, биелэлтийг ханган ажиллаж байх.

**3. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт 4:**

Тус байгууллага нь "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг батлуулсан боловч үйл ажиллагаандаа мөрдөхөд учир дутагдалтай, байгууллагын хэлбэрийг буруу тодорхойлсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

"Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамд нийцүүлэн шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орхон аймгийн Хот тохижуулах газар	3	874,329.6	1	88,177.5	1	786,152.1	3	874,329.6				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>874,329.6</b>	<b>1</b>	<b>88,177.5</b>	<b>1</b>	<b>786,152.1</b>	<b>3</b>	<b>874,329.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Хот тохижуулах газар	10	293,864.8	1	1,000.0	4	281,375.9	4	9,275.0	1	2		

Дүн	10	293,864.8	1	1,000.0	4	281,375.9	4	9,275.0	1	2		
-----	----	-----------	---	---------	---	-----------	---	---------	---	---	--	--

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Орхон аймгийн Хот тохижуулах газар	1	-						1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>						<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Орхон аймгийн Хот тохижуулах газар									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>						<b>1</b>	<b>-</b>

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		